

Ноагийн үерээс хойш их цаг хугацаа өнгөрөв.

Дэлхий дээр Ноагийн үр удам олширч, хамтдаа амьдарцгааж, бүгд нэг хэлээр ярьдаг байлаа.

Тэд дорно зүг уруу нүүж, Шинар газрын нэгэн талд хамтдаа нутаглан суух болжээ.

Хүмүүс олуулаа амьдарч байсан учир тосгон ч аажмаар томорч эхэлжээ.

Хүмүүс ухаантай болох түсам Бурханыг тоохгүй амьдрах болов.

Тэд харин ч өөрсдөө Бурхан шиг болохыг бодож эхэлжээ.

Бага багаар шуналтай болж байгаа хүмүүс маш өндөр цамхаг барьж эхэлжээ.

Хүмүүс тэнгэрт тулам өндөр цамхагийг барьцгаая хэмээн барьж эхлэв.

Хүмүүс энэ цамхгийг барихаасаа өмнө Бурханаас ч асуулгүйгээр өөрсдөдөө таалагдахаар барьж эхлэв. Хүмүүс бардам болж, Бурханыг хүндэтгэх сэтгэлгүй болсон байлаа.

Бурхан хүмүүсийн барьж байгаа цамхгийг харжээ. Тэр цамхаг Бурханд таалагдсангүй.

Тиймээс Бурхан тэднийг нэг болгохгүйн тулд тэдний хэлийг өөр өөр болгон сольж хутгалдуулан орхижээ.

Би биенээ буруу ойлголцож байсан тул ихэд үймэцгээн хамтдаа амьдрах боломжгүй болжээ.

Тэнгэрт тултал барьж байсан цамхгаа орхин тус тусын замаараа явцгаажээ.

Ийм сонин гайхалтай зүйл болсонд тэд, Бурхан хүч чадалтай Нэгэн болохыг мэдэж авчээ.

Тэгээд хамтдаа барьж байсан цамхгаа “Бабел” гэж нэрлэжээ.





- Дараах библийн эшлэлийг дээр нь дагаж бицээд цээжлээрэй. (Эхлэл 11:9)

Уг газрыг Бабел гэж нэрлэв.





Bonjour

สวัสดีครับ

Hello

Ciao

你好

Hola

مرحبًا.

Salve

안녕

こんにちは

Hello

你好

안녕

สวัสดีครับ

Salve

Hola

Ciao

こんにちは

Bonjour

مرحبًا.

